



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 30

Арвайхээр

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 274 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өвөрхангай аймагт 2019-2022 онд хэрэгжүүлэх “Эрчим хүч хэмнэх дэд хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс үе шаттай санхүүжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулан явц, үр дүнг жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д үүрэг болгосугай.

4. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүхий л талаар хамтарч ажиллахыг аймгийн нийт төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд уриалсугай.

ДАРГА

А.ИШДОРЖ

100130051

Аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн  
2019 оны 04 дүгээр сарын 15 –ны өдрийн  
30 дугаар тогтоолын хавсралт



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ 2019-2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭХ ДЭД ХӨТӨЛБӨР**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын Их Хурлаар 2015 онд батлагдсан Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-д заасан “Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн талаар орон нутгийн бодлогыг тодорхойлж холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ”, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 274 дүгээр тогтоолоор баталсан 2018-2022 оны Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн 4.9.1-д “тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн онцлогт тохирсон эрчим хүч хэмнэлтийн талаарх бодлогыг тодорхойлж аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх” гэж заасан заалтуудыг үндэслэн аймгийн Засаг даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/429 тоот захирамжаар “Эрчим хүч хэмнэх дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг” томилогдон энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Өвөрхангай аймгийн статистикийн 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 34652 айл өрх, 2021 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Өвөрхангай аймгийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний салбарууд нь 110/35/10/0,4/0,2 Квольтын цахилгаан дамжуулах, түгээх шугам сүлжээгээр дамжуулан 7 аймаг, 40 сумын 2 багт цахилгаан дамжуулж байна.

Манай аймгийн 1249 аж ахуйн нэгж, орон сууцны 1783, гэр хорооллын 14281 айл өрх төвлөрсөн цахилгаан түгээх сүлжээнд холбогдож цахилгаан эрчим хүч хэрэглэж байна.

“ЭБЦТС ТӨХК”-ийн салбаруудын тайлангаас харахад цахилгаан түгээлтийн алдагдал 14,7% буюу олон улсын жишгээр хэвийн бус алдагдалтай байна. /0-0.5 хувь алдагдалгүй, 0.5-10 хувь хэвийн, 10 хувиас дээш хэвийн бус алдагдалтай гэж үздэг/

Манай аймагт төсвийн 174, аж ахуйн нэгжийн 138 барилгууд, 2224 айл өрх буюу нийт өрхийн 6.4 хувь нь дулаанаар хангагдаж үлдсэн айл өрх, аж ахуйн нэгж нь ердийн галлагаатай зуух, нам даралтын зуухаар халаалтын асуудлаа шийдэж байна.

Хүн ам, барилгажилт нэмэгдэж цахилгаан, дулааны хэрэглээ өсөн нэмэгдэж байна.

Цахилгаан, дулааны эрчим хүчийг үр ашигтай хэрэглэх нь төсөв хэмнэх, өрхийн болон байгууллага аж ахуйн нэгжийн зардлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх, зүй зохистой хэрэглээг төлөвшүүлэх, ард иргэдийн ая тухтай аюулгүй амьдрах орчныг сайжруулах давуу талыг бий болгодог.

**Тулгамдаж буй асуудал**

Аймгийн эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах төрийн нэгдсэн бодлогын хүрээнд эрчим хүчийг хэмнэх, түүний үр ашгийг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, нийтийн боловсролд чиглэсэн эрчим хүчний хэмнэлтийн талаарх мэдээлэл, сурталчилгааны нэгдсэн системийг бий болгох, барилга байгууламжийн зураг

төсөлд эрчим хүчний хэмнэлттэй, ашиглалтын зардал багатай шийдлүүдийг тусгах, барилга, шугам сүлжээний дулаан алдагдлыг бууруулах зэрэг шаардлагатай арга хэмжээнүүдийг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай байна.

19 сум 2 багийн төвд дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлөөр 31 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс Арвайхээр суманд 9 тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаа явуулж байна.

Хэдий ийм боловч зуухнуудын технологийг төдийлөн сайжруулж чадахгүй байгаагаас утааны хийгээр их хэмжээний дулаан алдагдан өндөр зардлаар дулааныг үйлдвэрлэж, суурин газруудын агаарыг ихээр бохирдуулж байгаа нь хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна.

УЦУОШГазраас хийсэн агаарын чанарын үзүүлэлтийн хэмжилтээс харахад Арвайхээр суманд өвлийн улиралд тоосонцрын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс 0.9-3 дахин их байна. /Арвайхээр сумын хэмжээнд хийсэн хэмжилтээс/

Зарим барилгууд дулааны алдагдал ихтэй, гадна дулааны шугамууд хуучирч муудсан, тохируулга муутайгаас зарим хэрэглэгчдийг чанарын шаардлага хангасан дулаанаар хангаж чадахгүй байна.

### **Хоёр. Дэд хөтөлбөрийн зорилго**

2.1 Орон нутагт эрчим хүч хэрэглэгчдэд эрчим хүч хэмнэх тодорхой хэмжээний мэдлэг олгох, эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, хэрэглэх замаар дулаан, цахилгааны алдагдлыг багасгаж, төсөв зардал хэмнэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж хүний эрүүл аюулгүй амьдрах таатай нөхцөлийг сайжруулахад хөтөлбөрийн зорилго оршино. Өвөрхангай аймгийн Засаг даргын 2019-2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй нягт уялдуулан хэрэгжүүлнэ.

### **Гурав. Дэд хөтөлбөрийн зорилт**

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах нийтлэг зорилтыг дэвшүүлж байна.

3.1 Орон нутагт баримтлах эрчим хүч хэмнэлтийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

3.2 Орон нутгийн харьяа эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд явуулах хэмнэлтийн бодлогыг тодорхойлох

3.3 Эрчим хүч хэмнэлтийг хэрэгжүүлэх хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх

3.4 Эрчим хүч дамжуулалт, түгээлтийн үр ашгийг нэмэгдүүлж, цахилгаан болон дулаан түгээлтийн алдагдлыг бууруулах

3.5 Иргэд олон нийтэд эрчим хүч хэмнэлт, үр ашигтай хэрэглээний талаарх мэдээлэл сурталчилгааг явуулж эрчим хүчний зохистой хэрэглээг бий болгож хэвшүүлэх

3.6 Барилга байгууламжийг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөх, ашиглалтыг сайжруулж, дулааны алдагдлыг бууруулах

3.7 Эрчим хүч хэмнэх мэдээллийн сантай болох

3.8 Төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, бусад төсөвт байгууллагын эрчим хүчний хэрэглээг бууруулах, хэмнэлт гаргах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх

3.9 Эрчим хүч хэмнэлтийг тарифын бодлогоор дэмжих

3.10 Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламжийн зураг төсөл хийх, барьж байгуулах, үйлдвэрлэл үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр холбогдох инженер, техникийн ажилтныг чадавхжуулах.

3.11 Дулааны станцыг ашиглалтад оруулах

3.12 Түлшний бүрэн шаталттай зуухыг гэр хорооллын айл өрхүүдэд нийлүүлэх

## **Дөрөв. Дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажил**

4.1 Орон нутагт эрчим хүч хэмнэлтийн бодлого хэрэгжүүлэх үндсэн чиглэлүүдийг тодорхойлох

4.1.1 Эрчим хүч хэмнэх үйл ажиллагааны төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх

4.1.2 Эрчим хүч хэрэглэдэг томоохон аж ахуйн нэгж байгууллагуудын бүртгэлийг хийх, тэдгээр байгууллагуудад эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийн ажлыг зохион байгуулахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах

4.2 Орон нутгийн харьяа эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд явуулах хэмнэлтийн бодлогыг тодорхойлох

4.2.1 Эрчим хүчний үйлдвэрлэл түгээлтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

4.2.2 Их урсгал засварыг эрчим хүч хэмнэлттэй материалаар хийж гүйцэтгэх

4.3 Эрчим хүч хэмнэлтийг хэрэгжүүлэх хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх

4.3.1 Эрчим хүч хэмнэлтийн багш бэлтгэх

4.3.2 Эрчим хүчний /дулаан, цахилгааны/ инженер техникийн ажилтныг холбогдох сургалтад хамруулж мэргэшүүлэх

4.4 Цахилгаан, дулаан түгээлтийн алдагдлыг бууруулж үр ашгийг дээшлүүлэх

4.4.1 Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт үр ашгийн тооцоо хийлгүүлж хэвших, эрчим хүчний хэмнэлттэй байдлаар төлөвлөж хийлгүүлэх, хэрэгжилтийг хянах

4.4.2 Дулааны эрчим хүчний үйлдвэрлэлд дэвшилтэд технологи нэвтрүүлэх замаар түлшний шаталтыг сайжруулж, зардал болон агаарт хаях тоосонцрын хэмжээг бууруулах

4.4.3 Баянтээгийн нүүрсний уурхайг түшиглэн нүүрс коксжуулах үйлдвэр барих

4.4.4 Техник, технологийг шинэчлэх замаар дулаан дамжуулах шугам сүлжээнд мэргэжлийн байгууллагаар гидравлик тооцоог хийлгэн, тохируулга, зүгшрүүлэлтийг жигдрүүлэх арга хэмжээ авч эрчим хүчний алдагдлыг бууруулах

4.4.5 Халаалтын эхлэх, дуусах хугацааг бүсчилсэн хэлбэрээр тогтоолгох

4.4.6 Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөг оны эхэнд гаргуулж, 9, 10 дугаар сард барилга байгууламжийн дулаалга бүрэн хэмжээгээр хийгдсэн байх

4.4.7 Дулааны хэрэглээг тоолуураар тооцох үндсэн нөхцөлийг бүрдүүлэх, тоолуурын заалтаар төлбөр тооцоог хийх тогтолцоог судлах, хэрэгжүүлэх

4.4.8 Дэвшилтэд технологи нэвтрүүлэх замаар хуучирч муудсан цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөөг өргөтгөж шинэчлэх

4.4.9 Цахилгааны тарифт /ухаалаг/ тоолуурт шилжүүлж зүй бус хэрэглээг бууруулах.

4.4.10 Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн гэрэлтүүлэгт эрчим хүчний хэмнэлттэй технологийг үе шаттайгаар нэвтрүүлэх

4.4.11 "Эх дэлхийн цаг"-аар буюу жил бүрийн гуравдугаар сарын сүүлийн бямба гаригийн 20 цаг 30 минутад нэг цагийн турш нэгэн зэрэг гэрлээ унтрааж хүлэмжийн хийг багасгах үйл ажиллагаанд нэгдэх

4.5 Иргэд олон нийтэд эрчим хүч хэмнэлт, үр ашигтай хэрэглээний талаарх мэдээлэл сурталчилгааг явуулж эрчим хүчний зохистой хэрэглээг бий болгож хэвшүүлэх

4.5.1 Иргэд олон нийтэд эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний талаар, сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах

4.5.2 Эрчим хүч хэмнэх өдөрлөг, үзэсгэлэн зохион байгуулж иргэд олон нийтэд нээлттэй мэдээ мэдээлэл өгөх, ажлыг зохион байгуулах /Эрчим хүчний хэмнэлттэй бараа, барилгын материал, дулааны тусгаарлагын материал гэх мэт/

4.6 Барилга байгууламжийг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөх, ашиглалтыг сайжруулж, дулааны алдагдлыг бууруулах

4.6.1 Барилга байгууламжийн эрчим хүчний хэрэглээний түвшинг тодорхойлж ашиглалтыг сайжруулах /дулаан алдагдлын байдалд хэмжилт судалгаа хийх/

4.6.2 Улсын төсвийн болон орон нутгийн төсөв хөрөнгөөр баригдах барилгуудыг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөх, холбогдох стандартын шаардлага хангасан материалаар хийж гүйцэтгэхэд хяналт тавих

4.7 Эрчим хэмнэлтийн хүчний мэдээллийн сантай болох

### **Тав. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

5.1 Дэд хөтөлбөрийг 2019-2022 онд хэрэгжүүлнэ.

### **Зургаа. Дэд хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт**

6.1 Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

6.1.1 Эрчим хүч хэмнэлтийн бодлого хэрэгжүүлэх үндсэн чиглэлүүдийг тодорхойлсон байна.

6.1.2 Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, хэмнэлт хийх талаар төрийн байгууллага, эрчим хүчээр хангагч, хэрэглэгч байгууллагуудын хамтын ажиллагааны суурь тавигдсан байна.

6.1.3 Эрчим хүчийг үр ашигтай зарцуулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажил хэрэгжиж, иргэд, олон нийт, хүүхэд багачууд эрчим хүчний хэмнэлт-зохистой хэрэглээнд суралцаж, төлөвшсөн байна

6.1.4 Дулааны эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээнээс бий болж байгаа бохирдол бодитоор буурсан байна.

6.1.5 Цахилгаан, дулаан түгээлтийн алдагдал буурсан байна.

6.1.6 Барилга байгууламжийг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөж, ашиглалтыг сайжруулан, хэрэгжилтийг хангуулсан байна.

6.1.7 Дулааны станц ашиглалтад орсон байна.

6.1.8 Эрчим хүчний мэдээллийн нэгдсэн сантай болсон байна.

### **Долоо. Дэд хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр**

7.1 Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

7.1.1 Орон нутгийн сангийн эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээнд зарцуулах хөрөнгө оруулалтын эзлэх хэмжээ 5 хувь байна.

7.1.2 Улсын төсөв

7.1.3 Олон улсын байгууллагын зээл тусламж, төсөл хөтөлбөрийн санхүүжилт

7.1.4 Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө

7.1.5 Банк бус байгууллагын хөнгөлөлттэй зээл

7.1.6 Олон улсын байгууллагын байгаль хамгаалах сангийн санхүүжилт, хөрөнгө оруулалт

7.1.7 Бусад эх үүсвэр

## **Найм. Удирдлага, зохион байгуулалт**

8.1 Хөтөлбөрийн нэгдсэн удирдлага зохицуулалтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс хариуцна.

8.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Эрчим хүчний зохицуулах зөвлөл хамтран гүйцэтгэнэ.

## **Ес. Хяналт шинжилгээ, үр дүн шалгуур үзүүлэлт**

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зорилт, үйл ажиллагааны үр дүнгээр үнэлнэ.

9.2 Хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс хяналт шинжилгээ үнэлгээг гүйцэтгэж тайлангаа Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлнэ.